



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/32

Ховд

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх Эвийн хүч худалдааны төвийн уурын зуухны гадна шугам сүлжээний засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: С.Гантөмөр -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Гомбосүрэн -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын хэлтсийн дарга

Б.Дэлгэрмаа -Төрийн бус байгууллагын төлөөлөл

Х.Жангарзүсэм - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга /С.Гантөмөр /-д үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2019 тг А/32 Чх
02 130